



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 13 өдөр

Дугаар 6/Н

Чингис хот

Музейн захирал Н.Нямсүрэнд  
сахилгын шийтгэл ногдуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6, Хөдөлмөрийн тухай хуулийн 131.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Аймаг дахь Төрийн аудитын газраас Орон нутаг судлах музейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай санал дүгнэлт гарсан тул тус газрын 2020 оны 57/57 тоот албан шаардлагын дагуу Музейн захирал Н.Нямсүрэнд сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Албан үүргээ холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд биелүүлж ажиллахыг Музейн захирал Н.Нямсүрэнд үүрэг болгосугай.

3. Захирлын ажлыг мэргэжил арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, урлагийн газар /С.Мөнхцэцэг/-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА